

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
1.	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	5-8
	<b>1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	5-8

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны төвч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилоптой: Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Батболд, Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Ц.Сэргэлэн.

**Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорлоо, Тагнуулын ерөнхий газрын дэд дарга, С.Хүдэрчулуун, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Ц.Хүрэлбаатар, Мэдээллийн аюулгүй байдлын газрын Хэлтсийн дарга Д.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Баттөмөр:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулахыг уриалсан, сурталчилсан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Байнгын хорооны саналаар, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэснийг “үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэж өөрчлөн, үүнтэй уялдуулан 6.1.1 дэх заалтын “тэмдэг, үндэсний өв соёл, зан заншил болон түүх, соёлын үнэт зүйлийг” гэснийг “тэмдгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

3.Байнгын хорооны саналаар, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулан, үүнтэй уялдуулан төслийн 6.2.1 дэх заалт, 6.3 дахь хэсгийг хасч, “6.2.2-6.2.5” дахь заалтын дугаарыг “6.2.1-6.2.4” гэж өөрчлөх:

“6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

**Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Баттөмөр:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22.2.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.5.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын

саналыг үндэслэн, Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Баттөмөр:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжиагдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулаэв.

**Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Баттөмөр:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “хүсэлтийг” гэснийг “хүсэлт, шийдвэрийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

3	
е Татгалзсан:	3
в Бүгд:	11
ш 72.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

е Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн раатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

е  
н **Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Баттөмөр:** 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 21.2.8 дахь заалтын “зогсоох зорилгоор хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг” гэснийг “зогсоох зорилгоор зөрчилтэй контентын тархцыг бууруулах, хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд

эдгээр арга хэмжээг" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 17 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.7 хувийн ирцтэйгээр 09 цаг 58 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.БАТТӨМӨР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Баттөмөр:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ирцийг танилцуульяа. Энх-Амгалан гишүүн чөлөөтэй байгаа, Алтанхуяг гишүүн орж ирэх байх гэж бодож байна. Амартувшин байна, Аюурсайхан байна, Бат-Амгалан байна, Баттөмөр байна, Баделхан байна, Б.Бат-Эрдэнэ байна, Доржханд байна, Дэлгэрсайхан байна, Наранбаатар байна, Цогтбаатар байна, Нямаагийн Энхболд чөлөөтэй байгаа юм байна. Энд орж ирж амжаагүй байгаа гишүүд хуралдаа орж ирэхийг урьж байна.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуульяа.

**Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.** Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийн гишүүдийг оруульяа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуульяа. Учрал сайд байна. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, Ганбатын Нарантуяа Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн, Сүрэнжавын Хүдэрчулзуун Тагнуулын ерөнхий газрын дэд дарга, Цэгмэдийн Хүрэлбаатар Тагнуулын ерөнхий газрын Мэдээлэл аюулгүй байдлын газрын дарга, Даваадоржийн Ганзориг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа. Танилцуулгыг би уншиж танилцуульяа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн Их Хурлын чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээрх хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Тус Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах, хуулийн төсөл, зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар санал хураалт явуулахгүйгээр нээлттэй үлдээж, Байнгын хороонд шилжүүлсний дагуу бэлтгэсэн саналын томьёоллууд болон санал хурааж дэмжигдсэн боловч Байнгын хорооны хуралдаанаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн саналыг бэлтгэж та бүхэнд тараасан болно

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллын шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа гэсэн танилцуулга байна.

Нэгдсэн хуралдаанаас хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Учралаас зарчмын зөрүүтэй зарим саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр үг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулах чиглэл өгөхийг хуралдаан даргалагчаас хүссэн. Иймээс хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулах талаар санал хураалт явуулъя.

Саналын томьёоллуудыг уншиж тусад нь санал хураалгана.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “хүсэлтийг” гэснийг “хүсэлт, шийдвэрийг” гэж өөрчлөх. Санал хураалт. Саяны ярьсныг өөрчилж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан санал хураах томьёолол.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулахыг уриалсан, сурталчилсан;” Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 10 гишүүн дэмжиж 90.9 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэснийг “үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн” гэж өөрчлөн, үүнтэй уялдуулан 6.1.1 дэх заалтын “тэмдэг, үндэсний өв соёл, зан заншил болон түүх, соёлын үнэт зүйлийг” гэснийг “тэмдгийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулан, үүнтэй уялдуулан төслийн 6.2.1 дэх заалт, 6.3 дахь хэсгийг хасаж, “6.2.2-6.2.5” дахь заалтын дугаарыг “6.2.1-6.2.4” гэж өөрчлөх:

“6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;” Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 9 зөвшөөрч 81.8 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22.2.5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.5.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн, Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоох.” Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Цогтбаатар гишүүн дэмжсэн байна. Санал хураалтад 11 гишүүн оролцож 8 гишүүн зөвшөөрч, 72.7 хувийн санал дээр нь Цогтбаатар гишүүн дэмжсэн 81.8 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед санал хурааж дэмжигдсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай 2 саналаар дахин санал хураалт явуулья гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь

дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Байнгын хороо санал хураалт явуулж болно гэж заасан. Ингээд дахин санал хураалт явуулъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд 11 гишүүн оролцож 9 гишүүн зөвшөөрч 81.8 хувийн саналаар санал дэмжигдэж байна. Дахин санал хураалт явуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дэмжсэн байна. Иймээс доорх саналуудаар санал хураалт явуулъя.

Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан санал хураалт хураах томьёолол.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “хүсэлтийг” гэснийг “хүсэлт, шийдвэрийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож 9 гишүүн дэмжиж, 81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Цогтбаатар гишүүн дэмжсэн байна. Цогтбаатар гишүүн картаа солиод хийчих.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 21.2.8 дахь заалтын “зогсоох зорилгоор хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг” гэснийг “зогсоох зорилгоор зөрчилтэй контентын тархцыг бууруулах, хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд эдгээр арга хэмжээг” гэж өөрчлөх. Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож 10 гишүүн дэмжиж 90.9 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. Санал хураалт явагдаж дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүн Бат-Амгалан гишүүнийг томилъё.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ